Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаарр хавсралт

# ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /мян.төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1.ТӨРИЙН БҮТЭЭМЖ-ЦАХИМ ЗАСАГЛАЛ** | | | | | | | |
| Зорилт1:Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай рууль бусад хууль тогтоомж болон энэхүү гэрээгээр хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, үр дүнг сумын Засаг даргын өмнө хариуцна. | | | | | | | |
| 1.1 | Хууль тогтоомж, Засгийн газар, аймаг, сумын ИТХ, Засаг даргаас гаргасан бодлогын баримт бичиг, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг удирдлага зохицуулалтаар хангаж, явц гүйцэтгэлийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах. | 200,0 | Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг<br>-Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлсэн байдал<br>-Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдал | Бодлогын баримт бичгүүдийг ЗДТГ-ын албан хаагчид болон төрийн байгууллагуудад танилцуулж, хагас бүтэн жилээр тайланг авч нэгтгэн холбогдох байгууллагат тайлагнадаг. | Төрийн байгууллагууд болон багийн засаг дарга нар, төрийн албан хаагчдад шийдвэрийг тухай бүр танилцуулан хэрэгжилтийг зохион байгуулах, тайланг хугацаанд нэгтгэн дүгнэж хүргүүлэх | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт Монгол улсын хууль 9, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол 3, Ерөнхийлөгчийн зарлиг 7, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл 4, Засгийн газрын тогтоол 40, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 13, Засгийн газрын албан даалгавар 4, аймгийн Засаг даргын албан даалгавар 1, аймаг, сумын ИТХ, Засаг даргаас гаргасан бодлогын баримт бичиг, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | -Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдал<br>-Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлсэн байдал<br>-Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдал<br>-Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байдал<br>-Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байдал | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2 | Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг хангаж ажиллахад хяналт тавих | 200,0 | Тайланг хугацаанд нь нэгтгэн тайлагнасан байх | Хагас бүтэн жилээр хэрэгжилтийг тайлагнадаг. | Хагас бүтэн жилээр төрийн байгуулагууд болон албан хаагчдаас холбогдох заалтын хэрэгжилт, хөтөлбөрийн тайланг авч нэгтгэн дүгнэж тайлагнах | | |
| 1,3 | Шинээр болон шинэчлэн батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, тэдгээрийг байгууллага, албан хаагч, иргэд, олон нийтэд сурталчлан таниулах сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах | 500,0 | Зохион байгуулсан сургалтын тоогоор | Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль<br>-Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль<br>-Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль<br>-Малчны тухай хууль<br>-Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль | Хууль тогтоомжийг сурталчлах ажлыг хариуцлагатай айгаар зохион байгуулж, төрийн албан хаагч, иргэдийн эрх зүйн боловсролыг нэмэгдүүлсэн байна. | Шинээр батлагдан гарсан Малчны тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Мал амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль зэргээр холбогдох албан хаагч нартай хөдөөгийн 3 багаар явж 150 гаруй малчин иргэдэд мэдээ мэдээлэл хүргэсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | -Хүүхэд хамгааллын тухай хууль шинэчилсэн найруулга<br>-Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль<br>-УИХ-ын 2024 оны 52 дугаар тогтоол “Засгийн газарт чиглэл өгөх тухай” | | | |
| 1.4 | “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлалсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, иргэдийн орон нутагт шилжин, тогтвортой суурьших орчин нөхцөлийг бүрдүүлэх, төрийн албан хаагчийн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, хот, хөдөөгийн хөгжлийн зохист тэнцвэрийг хадгалах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, энэ хүрээнд уг | 800,0 | Зохион байгуулж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоогоор | 15 төрийн албан хаагчыг хуучин дотуур байранд түрээсийн төлбөргүй байрлуулж байна. Төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгож байна. | Монгол Улсын Их Хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолын хэрэгжилтий г зохион байгуулж ажилласан байдал | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолын дагуу төрийн албан хаагчдийн цалинг Хүний нөөцийн цалингийн системд өөрчлөлт оруулж шинэчлэн, Цалингийн нэгдсэн системээр 7 төсөвт байгууллагын давхардсан тоогоор 130 албан хаагчийн 1,417,690.7 мянган төгрөгний цалин, урамшуулал, 177,211.3 мянган төгрөгний ндшимтгэлийн гүйлгээг дамжуулан олгосон байна. Гарт олгох цалин, ндш, хаоат татварын гүйлгээг заавал Цалингийн нэгдсэн системээр дамжуулан олгож байгаа. Хуулийн дагуу Урьдчилгаа цалин, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтоолд заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах | | | | | 2-р хагасын цалин гэж 2 хуваан олгож байгаа.<br>Нийт Орон нутгийн төсөв 2,271,967.1 мянган төгрөг, үүнээс ИТХурал 302,548.7 мянган төгрөг, ЗДТГазар 1,567,748.3 мянган төгрөг, Улсын төсвийн байгууллагуудын тогтмол зардал 401,670.0 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сан 161,000.0 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 690,000.0 мянган төгрөг, Эрсдэлээс хамгаалах сан 100,000.0 мянган төгрөгөөр тус тус батлагдсан.<br>2025 онд Орон нутгийн нэмэгдэлийг Төрийн захиргааны албан хаагчид 40 хувь, Төрийн үйлчилгээний албан хаагчид 40 хувийн нэмэгдэл олгож байна. | |
| 1.5 | Нийтийн мэдээлэл хариуцагч байгууллага бүр Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, кибер аюулгүй байдлын дотоод журмыг баталж, мөрдөх | - | Дотоод журмыг шинэчлэн батлах, албан хаагчдад кибер аюулгүй байдлын тухай хуулийг сурталчилах | -кибер аюулгүй байдлын журам гаргаж баталсан байна. | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, ил тод байдлын үзүүлэлтийг хангасан байна. | Кибер аюулгүй байдлын тухай хуулийг судалж байгууллагын албан хаагчдад танилцуулсан. Санхүү болон төсөл хөтөлбөрийн програмыг лицензтэй програм ашиглаж байна. Төрийн албыг монгол бичгээр хослуулан хөтлөх болсонтой холбогдуулан монгол бичгийн лицензтэй прогрмыг архив, бичиг хэрэгтээ ашиглаж байна. | |
| 1.6 | Дээд шатны байгууллагууд болон аймгийн Засаг даргаас өгсөн хугацаатай үүрэг даалгавар, тайлан мэдээ, | | -Тухай бүр хугацаанд нь ирүүлсэн байдал<br><br>-Албан бичгийн | Тухай бүр мэдээ, албан бичгийн хариуг явуулахад хяналт тавьж | Тайлан мэдээ, албан бичгийг стандартын | Дээд газраас нийт 114 албан бичиг ирсэн, үүнээс хариутай 45 албан бичиг ирүүлсэн байна. Дээрх албан бичгүүдийн хариуг хугацаанд нь илгээж, албан хэрэг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | албан бичгийн хариуг хугацаанд нь ирүүлэх, тэдгээрийг албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, баримт бичгийн стандартын дагуу боловсруулахад онцгойлон анхаарах | 300,0 | боловсруулалтад Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ыг мөрдөж ажилласан байдал | ажилласан байна. | дагуу боловсруулсан байна. | хөтлөлтийн стандарт журмын дагуу боловсруулан үйлдэж явуулсан. | |
| 1.7 | Иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэж, шийдвэрлэлтэнд дүн шинжилгээ хийж, албан тушаалтнуудын ажлын үр дүнг тооцох | - | -Хуулийн хугацаанд хүнд суртал, чирэгдэлгүй шийдвэрлэж, хариу өгсөн байдал<br><br>-Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг аймгийн Засаг даргын Тамгын газарт хугацаанд нь нэгтгэн ирүүлсэн байдал | Өргөдөл гомдлыг хүлээж авах процесс удааширалтай. | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж тайлангийн чанарт онцгой анхаарч ажилласан байна | Эхний хагас жилийн байдлаар иргэдээс ирсэн өргөдөл, гомдол, санал, мэдэгдэл нийт 21, үүнээс Сангийн яамнаас худалдан авах ажиллагаатай холбоотой гомдол хянасан тухай 3, ИТХ-ын төлөөлөгчдөөс тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих тухай гомдол 1, алдарт эхийн одонд хамрагдах тухай хүсэлт 1, байгууллагын дотоод асуудал, үйлчилгээ авах хүсэлт 6, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай мэдэгдэл 2, санал 3 ирсэн байна. Шийдвэрлэж хариу өгсөн байдал нь харьяалалын дагуу 2 гомдлын шилжүүлж, албан бичгээр хариу мэдэгдсэн 12, биечлэн 2 шийдвэрлэж хуулийн хугацаанд хүнд суртал, чирэгдэлгүй шийдвэрлэж хариу өгсөн байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг аймгийн Засаг даргын Тамгын газарт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хугацаанд нь нэгтгэн хүргүүлж хэвшсэн байна. | |
| 1.8 | Байгууллагын удирдлагын системийг хэрэглээнд нэвтрүүлж, тоон гарын үсгийг ашиглаж, албан бичгийг цахимаар солилцож хэвших | 500,0 | Тоон гарын үсгээр баталгаажуулж, цахимаар илгээсэн албан бичгийн тоо | Байгууллагын төсвийн гүйлгээ тоон гарын үсгээр хийгдэж байна. | 100 хувь | Uv.ERP цахим системийг ЗДТГазарт нэвтрүүлээд байна. ЭМТөв, Соёлын төв, ЕБСургууль, цэцэрлэгийн байгууллагууд нэвтрүүлж албан хаагчдын мэдээллээ байршуулж эхлээд байна. Төрийн байгууллагын холбогдох албан хаагч нарт 2 удаагийн шаталсан сургалтыг аймгийн ЗДТГ-аас зохион байгуулаад байна. | |
| 1.9 | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэн, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг бодитой үнэлж, “маш сайн” үнэлэгдсэн төрийн захиргааны албан хаагчдад байгууллагын зүгээс сургалтын төлбөрийн хөнгөлөлт дэмжлэг үзүүлэн Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад хамруулах<br>*(Төрийн албаны тухай хуулийн 55.3)* | 2000,0 | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдал<br><br>-Байгууллагаас дэмжлэг үзүүлж, мэргэшүүлэх багц сургалтад хамруулсан албан хаагчдын тоо | Хагас бүтэн жилээр албан хаагчдын ажлын гүйцэтгэл үр дүнг дүгнэн урамшуулал олгон ажиллаж байна. | -Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 7 дугаар хавсралтаар батлагдсан аргачлалын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дагуу үнэлж, дүгнэсэн байна. | | |
| 1.10 | Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын болон төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сул орон тооны захиалга ирүүлэх, нэр дэвшүүлсэн иргэн, албан хаагчийг хууль тогтоомжийн хүрээнд томилох, сул орон тоонд хууль бус томилгоо хийхгүй байх | - | -Сул орон тоог олон нийтэд ил тод мэдээлсэн байдал<br>-Сул орон тооны захиалгыг хуулийн хугацаанд ирүүлсэн байдал<br>-Зөрчилтэй томилгоо хийгдээгүй байх<br>-Түр орлон гүйцэтгүүлэх үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцсэн байх | Сул орон тоо гарсан тухай бүр ажлын байрыг зарлуулан журмын дагуу сонгон шалгаруулж хуулийн дагуу томилж байна. | Төрийн албаны томилготой холбоотой шийдвэр хууль тогтоомжид нийцсэн байна.<br>-Томилготой холбоотой гомдол, маргаан гараагүй байна. | | |
| 1.11 | Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо (ХНУМТ) цахим системийн хөтлөлт, ашиглалт, мэдээллийн баяжилтыг тогтмол шинэчилж, байгууллагуудыг мэргэжил, арга зүйгээр хангаж, алдаатай мэдээллийг тухай бүр залруулах, системийн хамгаалалт, нууцлалыг хангаж ажиллах | | Баримт бичигтэй тулган үнэн зөв мэдээллийг бүрэн оруулсан байдал<br><br>-Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган үүрэгжүүлсэн байдал<br><br>-Нууцын баталгаа гаргуулсан байдал | Хүний нөөцийн системд албан хаагчдыг тухай бүр бүртгэн, баяжилт хийж байна. | -Албан хаагч бүрийн мэдээллийг өөрсдөөр нь баталгаажуулсан байна.<br>-Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн байна.<br>-Нууцийн баталгаа гаргасан байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.12 | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг мөрдөх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх | | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлан таниулах талаар зохион байгуулсан сургалтын тоо, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны тоо<br>- Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030 | Ёс зүйн дэд хороо байгуулагдан ажилласан. Албан хаагчдад 2 удаа сэтгэл зүйчийн сургалт зохион байгуулсан. | Төрийн албан хаагчинй ёс зүй, сахилга хариуцлагын зөрчилгүй ажилласан байна. | Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор<br>- “Эерэг бүхнээ хуваалцъя” 7 хоногийн аян,<br>- “Дулаахан яриа” сэдэвт мэргэжлийн Сэтгэл зүйчийн бүлгийн зөвлөгөө, сэтгэл зүйн оношилгоо,<br>- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль<br>- Байгууллагын дотоод журам танилцуулах<br>- Сэтгэл ханамжийн судалгаа<br>- Төрийн албан хаагчийн хууль, эрх зүйн мэдлэгийн түвшин тогтоох сорилыг тус тус авч ажилласан.<br>Байгууллагуудын ёс зүйн дэд хороодын гишүүдийг арга зүйгээр хангаж, Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын системп бүртгүүлэн үйл ажиллагаа, өргөдөл гомдлыг цахим системд бүртгэж эхэлсэн байна. | |
| 1.13 | Нутгийн захиргааны анхан шатны нэгжид ажиллаж байгаа төрийн албан хаагчид болон багийн Засаг дарга нарыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах | - | Сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдын тоо Багийн Засаг даргын тоо | Шинээр орсон албан хаагчдыг мэргэшүүлэх анхан шатны сургалтанд хамруулах, багийн дарга нарыг мэргэжил арга зүйн удирдлагаар | Төрийн албан хаагч 2-оос доошүй<br><br>Багийн Засаг дарга 100 хувь | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тогтмол хангаж, сургалтанд бүрэн хамруулах | | | |
| 1.14 | Төрийн албан хаагчдыг монгол бичгийн сургалтанд хамруулах | - | Монгол бичгийн чадвар сайжирсан албан хаагчийн тоогоор | Нийт албан хаагчийн 30 хувь монгол бичиг мэдэдгүй байсан. Монгол бичгийн цахим сургалтанд хамруулж, бие дааж сурах даалгавар өгч ажилласан. | Албан хаагчдын монгол бичгийн түвшинг оны эхэнд тогтоож хагас бүтэн жилээр үнэлнэ. Байгууллагын дотоод хаягуудыг монгол бичгээр солих | | |
| 1.15 | Сумын хэмжээнд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн орон нутагт хамаарах заалт болон авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх байгууллагын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, тайлагнах<br>Цахим хуудсанд байршуулж мэдээлэх | 200,0 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн орон нутагт хамаарах заалтын дагуу төлөвлөгөө гарган хагас бүтэн жилээр тайлагнаж ажилласан. | Төлөвлөгөөг боловсруулан батлуулах, байгууллагын цахим хуудсанд байршуулж мэдээллэх, | | |
| 1.16 | Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийг томилохын өмнө (түр орлон болон хавсран, туршилтын хугацаагаар) Авлигатай | - | Хуулийн хугацаанд ХАСУМ хянуулсан болон ХОМ гаргасан албан тушаалтны тоо | ХАСХУМ-1 хянуулж, ХАСХОМ-6 албан хаагч хугацаандаа тайлагнасан. | Удирдах албан тушаалтнуудад тухай бүр анхааруулж, | | |

<table>
<tr><td></td><td>тэмцэх газарт хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулах, томилогдсоны дараа 30 хоногийн дотор ХАСХОМ гаргах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулан, хуулийн заалтыг мөрдөж ажиллах</td><td></td><td></td><td></td><td>ХАСУМ хянуулах албан тушаалд томилогдсон албан хаагчийг хуулийн хугацаанд хөрөнгө орлогын мэдүүлгийг авах, ХАСХОМ гаргахад тухай бүр заавар зөвлөгөө өгч ажиллах</td><td></td><td></td></tr>
<tr><td colspan="8">2.ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРТ</td></tr>
<tr><td colspan="8">Зорилт 1: Орон нутгийн төсөв санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг боловсронгуй болгож, эх үүсвэр үр өгөөжийг нь дээшлүүлэх замаар сумын эдийн засгийн өсөлтийг хангана.</td></tr>
<tr><td>2.1</td><td>Төсвийн ил тод байдлыг хангах замаар шилэн дансны мэдээлэл байршуулалтад тогтмол хяналт тавих</td><td>-</td><td>Шилэн дансанд байршуулсан мэдээллийн тоогоор</td><td>Шилэн дансанд тухай бүр мэдээллийг хугацаанд нь байршуулж хэвшсэн.</td><td>Сар бүр шилэн дансанд төсвийн ил тод байдлыг ханган мэдээллийг байршуулах, мөн мэдээллийн самбарт төсвийн мэдээллийг тавих</td><td>Шилэн дансны мэдээллийн байршуулалт 98%-тай хугацаа хоцролт<br><table>
<tr><th>Шилэн дансны эрх</th><th>Хугацаанд аа оруулсан</th><th>Хугацаа хоцроосон</th><th>Та /1. ул</th></tr>
<tr><td>ТЕЗахирагч</td><td>77</td><td>1</td><td>Ху</td></tr>
<tr><td>ЕБС</td><td>67</td><td>2</td><td>Ху</td></tr>
<tr><td>Туяа</td><td>49</td><td>1</td><td>Ху</td></tr>
<tr><td>Цэцэрлэг</td><td>67</td><td>2</td><td>Ху</td></tr>
<tr><td>ЭМТөв</td><td>66</td><td>3</td><td>Ху</td></tr>
</table></td><td></td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Соёлын төв 69 0 Хугацаандаа<br>ИТХурал 49 1 Хугацаандаа<br>ЗДТгазар 67 2 Хугацаандаа<br>511 12 523 | |
| 2.2 | Бүх шатны худалдан авах ажиллагаанд болон түүний гүйцэтгэлийн явцад дотоод хяналт, шалгалтыг тогтмол явуулж, иргэд, олон нийт, ашиглагч байгууллагын зүгээс хяналт тавьж ажиллах боломжийг бүрдүүлнэ | 200,0 | - Хяналт шалгалт тавьсан тоогоор<br>Гэрээний гүйцэтгэлээр | Гэрээний хариуцлага сул, ажлын хэсгүүдийн уялдаа холбоо сул, хяналт тавих үйл ажиллагаа тогтмол бус | 2025 онд хийгдэх ХАА-нд дотоод хяналтыг тухай бүр тавьсан байх. Гэрээний гүйцэтгэл 100хувьд хүрсэн байх | Эхний хагас жилийн байдлаар Шууд гэрээ байгуулах аргаар 6, харьцуулалтын аргаар 8 худалдан авах ажиллагаа зохион байгуулсанаас 7 бараа, ажил, үйлчилгээг хүлээн авч, 3 гэрээ байгуулагдсан, хүлээж авах хугацаа болоогүй. 5 хөтөлбөр төсөл арга хэмжээнд оролцогч байхгүйгээс тендер амжилтгүй болж дахин зарлагдаж байна.<br>Нийт гэрээ байгуулагдсан 10 төсөл арга хэмжээнээс ИТХурал 5 төсөл арга хэмжээнд хяналт хийсэн. Захиалагчийн зүгээс 5 ажилд хяналт, үнэлгээ хийлээ. | |
| 2.3 | Худалдан авах ажиллагааны А3 сертифкатын сургалтанд албан хаагчдыг хамруулах | 1000,0 | - Сертифкат авсан албан хаагчдын тоогоор | Худалдан авах ажиллагааны сургалтанд 7 албан хаагч хамрагдаж сертифкат авсан. Худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. | Энэ онд төлөвлөгдсөн 30 ажлыг чнартай сайн зохион байгуулж ажилласан байх. Мэргэжил арга зүйн удирдлагаар бүрэн хангасан байх. | Худалдан авах ажиллагааны А3 серитификатын сургалтанд 7 иргэн, албан хаагч хамрагдсанаас 3 нь тэнцсэн. Нийт 1,047,818.0 мянган төгрөгний 33 төсөл арга хэмжээ худалдан авахаар төлөвлөсөн бөгөөд үүний 825,123.1 мянган төгрөгний 17 төсөл арга хэмжээг цахим тендер зарлахаар төлөвлөснөөс. Эхний хагас жилийн байдлаар 8 төсөл арга хэмжээг цахимаар зарласан байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.4 | Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөрийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, барагдуулах ажлыг зохион байгуулна. | 1000,0 | Өр зээлийг барагдуулсан дүнгээр | Хугацаа хэтэрсэн зээлдэгчдийн мэдээллийг монгол банкны мэдээллийн санд байршуулдаг. Хяналт шалгалтын ажлын хэсэг явж албан мэдэгдэл өгч ажилладаг | Зээлийн хугацаа хэтэрсэн иргэдийг шүүхрүү шилжүүлж өр авлагыг барагдуулна. Зээлдэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавина. | Тайлант сарын байдлаар Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь 80 %-д хүрч, чанаргүй зээлийн хэмжээ 12,5%-д хүрч буурсан байна. Сайн дурын эргэн төлөлт нэмэгдэж байгаа ч хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 8,941.0 мянган төгрөг болсон нь хяналт тавих шаардлага хэвээр байна. Санхүү дотоод хяналтын албаны хяналтын үнэлгээгээр чанаргүй зээлийн хэмжээ аймгийн түвшнээс өндөр байсан дүгнэлт гаргасан. Дүгнэлтийн дагуу чанаргүй зээл дээр ажиллаж 24,3 хувиас 12,5 хувь болгон бууруулсан. Мөн зээлийн гэрээний хугацаа дууссан зээлдэгчийн материалыг Аймгийн Сум Дундын Анхан Шатны Шүүхэд шилжүүлэн төлөгдсөн. | |
| 2.5 | Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг иргэдэд сурталчилах, татвар хураах үйл ажиллагааг зохион байгуулах | 500,0 | Төвлөрүүлсэн татварын хувь хэмжээгээр | Малын хөлийн татвар 80 хувьтай биелэгдсэн. | Малтай өрхүүдээс хуулийн дагуу албан татварыг хурааж орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, татварын тухай хууль тогтоомжийг сурталчилах | Малын тоо толгойн албан татварыг сумын ИТХ-аас тогтоосон хувь хэмжээгээр авч энэ жилийн төлөвлөгөөний биелэлт 52,1 сая төгрөг буюу 65 хувийн биелэлттэй байна. Малын тоо толгойн албан татварын өмнөх жилүүдийн өрийг барагдуулах зорилгоор шат дараалсан арга хэмжээ авч 154 малчинд нэхэмжлэх үүсгэн 116 малчны дансыг битүүмжилсэн. Эдгээр дансаа битүүмжлүүлсэн малчдаас 62 нь өрөө барагдуулж дансаа нээлгэсэн. Хагас жилийн байдлаар 2022 оны 6,8 сая, 2023 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оны 16,7 сая, 2024 оны 39,6 сая төгрөгний өрийн үлдэгдэлтэй байна. | |
| 2.6 | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын 3.7-д заасны дагуу байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хууль тогтоомжийн дагуу хуваарилагдах хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахгүй байх | - 150000,0 | Нэр заагдсан орлогын биелэлтийг бүрэн биелүүлэх<br><br>-Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу төлөвлөх | 2025 оны батлагдсан төсөв | Орлогыг бүрэн төвлөрүүлж, зарцуулалтыг зориулалтын дагуу зарцуулж үнэн зөв тайлагнана. | Сумын ИТХурлын тогтоолоор 2024 онд орж ирсэн Ан агнуурын төлбөрийн орлогын 50 хувь болох 160,200.0 мянган төгрөгний Байгаль орныг хамгаалах, нөхөн сэргээх 9 арга хэмжээг ИТхурлаар батлуулснаас<br>- Байгаль орчны хяналт шалгалт зохион байгуулахад шаардлагатай техник хэрэгсэл, Байгаль орчны хяналтын байцаагчийн хувцас, тоног төхөөрөмж<br>- Ан амьтны амьдрах орчныг сайжруулах, хамгаалалтын арга хэмжээ авах /Шувууны суултуур хийх гм/<br>“Тэрбум мод“ үндэсний хөдөлгөөний хүрээнд мод бут тарих, сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, тарьц суулгац худалдан авах ажлуудыг журмын дагуу хийж гүйцэтгэж байна. | |
| 2.7 | Улсаас явагдаж байгаа тооллого судалгаа болон хагас, бүтэн жилийн мал тооллогын ажлыг зохион байгуулах, боловсруулах, үр дүнг мэдээллэх | 4000,0 | Тооллого, судалгааг хугацаанд нь чанартай зохион байгуулах, үнэн зөв бодит байдлыг хангах | Хагас, бүтэн жилээр тооллого хийсэн байх | Сумын нутаг дэвсгэрт байгаа мал, тэжээвэр амьтдыг жилийн эцсийн тооллогод хугацаанд нь 100 хувь хамруулж, үр | Хагас жилийн малын түүвэр судалгаагаар нийт 211 өрх түүврээр сонгогдсон. Үүний дагуу судалгааг зохион байгуулах сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг байгуулах тухай А/83 дугаар захирамжийн дагуу багийн засаг дарга нар тухай багийн сонгогдсон өрхөөр 06 сарын 04-ноос 06 сарын 10-ний дотор мэдээллээ цуглуулан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дүнг боловсруулж, тархаасан байна. Хагас жилээр түүврээр сонгогдсон өрхийг бүрэн хамруулах | ажиллаж байна. Судалгааны зардалд 2386,2 төгрөг зарцуулахаар төсөвлөгдөж ирсэн. Судалгааны ажил 20-ны дотор бүрэн дуусч хүлээлгэн өгнө. | |
| 2.8 | Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, бүртгэл, ашиглалт, захиран зарцуулалтад хяналт шалгалтын ажлыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран зохион байгуулах | - | Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоогоор | - | 4-өөс доошгүй | Эхний хагас жилийн байдлаар зохион байгуулаагүй байгаа. | |
| **3. ХӨДӨӨ АЖ АХУЙ, БАЙГАЛЬ ОРЧИНЫ САЛБАРТ** | | | | | | | |
| **Зорилт 1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг тооноос чанарт шилжүүлэх бодлого баримталж, бэлчээр ашиглалтыг нэмэгдүүлэн, уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй болон туслах аж ахуйг хөгжүүлж хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг хангана.** | | | | | | | |
| 3.1 | Өвөлжилтийн бэлтгэл ажил, өвс тэжээлийн аюулгүй нөөцийн бүрдүүлэлтийг хангаж ажиллах | - 30000,0 | Биелэлтийн хувиар | 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг 82.5 хувиар хангасан | 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг 85 хувиас доошгүй хангасан байна. | Энэ жил зуншлагын байдал болон газрын гарцаас хамаарч малчид өөрсдийн хүчээр 1064 тн өвс бэлтгэхээс 741.0 тн, 40 тн гар тэжээл бэлтгэхээс 338.1 тн, хужир шүү 709 тн бэлтгэхээс 181.5 тн-ийг бэлтгээд байна. Сумын аюулгүйн нөөцөд одоогын байдлаар өвс , тэжээлийн татан авалт хийгээгүй байна. Нөөц бүрдүүлэхээр 35 сая төгрөг бэлэн байна.<br><br>Сумын төвийн нөөцөд татан авалт хийгээгүй. Сумын аж ахуйн нэгж, иргэд 65 га-д ногоон тэжээл | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тариалж, 130 тн ургац хураан авсан. | |
| 3.2 | Бэлчээрийн хөнөөлт мэрэгч үлийн цагаан оготнотой микробиологийн болон энгийн механик биологийн аргаар тэмцэж, ургамал хамгааллын ажлыг зохион байгуулах | - | Мэрэгчтэй тэмцсэн талбайн хэмжээгээр | Бэлчээрийн хөнөөлт мэрэгчгүй байсан. | Багийн дарга нараас судалгаа авч бэлчээр хөнөөлт мэрэгч ихэссэн тухай бүр арга хэмжээ авах | Сумын Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/50 дугаар захирамжаар Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдаж, бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай буюу оготно устгалын ажил 2025 оны 04 дугаар сарын 14-ны өдрөөс 04 дүгээр сарын 17-ны өдрийг дуустал хугацаанд 4 хоног зохион байгуулсан. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг Арвайн тал 2 дугаар багийн баянт толгой , Үйзэн, Хүрэмт 3-р багийн Хөндлөн булаг, шивээн далан, цагаан худгийн дэнж, сээрийн үзүүр, Их булаг -р багийн Цагаан дэрс, голын баруун дэнж, гоын өндөр, хунт, Наран булаг зэрэг газруудын нийт 4,0 мянган га талбайд 7 тонн бактержуулсан будааг цацах ажлыг хийсэн. Тус 3 багт нийт 3 хэсэг гарч ажилласан ба хэсэг тус бүрд ажлын бээлийн, амны хаалт, зэргийг хуваарилан өгсөн. Уг ажлыг гүйцэтгэхэд Арвайн тал багт 3 хүн, Хшрэмт 3 дугаар багт 3 хүн, Их булаг 5 дугаар багт малчдын оролцоотой 10 хүн, тус тус ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3 | Малын үндэсний бүртгэл мэдээллийн санд 2024 оны жилийн эцсийн малын тоог малчин өрх бүрээр оруулах, баяжилт тулгалт хийх ажлыг зохион байгуулах | 1000,0 | Малын тоог өрх бүрээр баяжилт хийж мэдээллийн санд бүртгэсэн байдлаар | Жил бүрийн эцэст малын тооллого зохион байгуулж, бүртгэл мэдээллийг хөтөлдөг байсан. | Мал тооллогыг баг бүрт чанартай зохион байгуулж, малчин өрх бүрийг мэдээллийн санд үнэн зөв бүртгэсэн байна. | 2024 онд 1071 өрх мал тоолуулсан. үүнээс мэдээллийн санд бүртгэгдсэн 1037 өрхийн мэдээллийг статистик мэдээлэлтэй тулган баяжилт шинэчлэлтийг 100% хийж гүйцэтгэсэн. хийж гүйцэтгэв. Шинээр мал тоолуулсан 32 малчны мэдээллийг шинээр бүртгэж праграммд оруулсан. Бусад аймаг сумдаас шилжиж ирсэн 45 малчин өрхийн мэдээлэл мал эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээгээр шилжиж ирэх тул хүлээгдэж байна. Мөн нас барсан болон 2024 онд мал тоолуулаагүй 33 малчины мэдээллийг идэвхигүй төлөвт оруулж баяжилтыг хийж байна. 2023 оны жилийн эцсээр мэдээллийн санд бүртгэлтэй 863 өрх байсан бол энэ онд 1037 өрхийн мэдээлэл бүртгэж өмнөх оноос 174 өрхөөр нэмэгдүүлж баяжилтыг хийлээ. Мөн тол бойжилт мал төллөлт, том мал зүй бус хоргодолын мэдээг 7 хоног бүр мэдээллийн санд оруулж баяжилтыг тухай бүр хийж байна. | |
| 3.4 | Хувиараа бизнес эрхлэх иргэдийг ажлын байраар хангах, зарим нэг үйл ажиллагаанд тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх | - | Бизнес хөгжлийн төвийг засварлан ашиглалтанд оруулах | Ажлын байр байдаггүйгээс өрхийн үйлдвэрлэл эрхлэгч нар гэрээр үйл ажиллагаа | Бизнес хөгжлийн төвийн тендэрийг зарлаж ашиглалтан | Бизнес хөгжлийн төвийг засварлах Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэх ажлын тендерийг зарлан 62 сая төгрөгөөр засварлах ажил хийгдэж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | явуулдаг, борлуулалт хангалтгүй. | д бүрэн оруулах<br>Үйл ажиллагаа эрхлэх иргэдийн судалгааг гаргаж, жлын байраар хангах<br>Зарим үйл ажиллагааг тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн байх | | |
| 3.5 | Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн зөвлөгөөн, сургалт уулзалтыг зохион байгуулах | 2000,0 | Суманд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн судалгааг гаргасан байх | Жил бүр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн судалгааг гарган баяжилт хийсэн | Суманд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн уулзалтыг зохион байгуулж, сургах, туршлага судлуулах, ажлын байраар үйл ажиллагааг шат дараатай зохион байгуулсан байна. | Хүнсний худалдаа үйлчилгээнд 6, нийтийн хоол үйлдвэрлэлийн салбарт 4, нийт иргэн 10, аж ахуй нэгж дээрх салбаруудад үйл ажиллагаа эрхэлж, 500 гаруй хүнийг ажлын байраар хангаж байна.<br>Нийтийн хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчид 1 -аар өссөн дүнтэй байна.<br>ОНХсангийн санхүүжилттэйгээр “Бизнес хөгжлийн төв” завсарлах ажлын тендерийг зарлан. Одоогоор засварын ажил хийгдэж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.6 | Хоршоог хөгжүүлэх сангийн талаар сурталчилан таниулж, ажлын хэсгийг ИТХ-аар батлуулан төсөл хүлээн авч сонгон шалгаруулж зээлийн гэрээ байгуулан зээл олгож үйл ажиллагааг нь дэмжсэн байна. | 100,0 | Сурталчилгааны тоо, зээлд хамрагдсан хоршоодын тоогоор | Сум хөгжүүлэх сан нэртэй байсан. Зээлийн эргэн төлөлт дутуу, хэрэгжилт хангалтгүй байсан. | Урьд зээл авсан иргэдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зээлийн зориулалт бусаар ашигласан иргэдийг шүүхрүү шилжүүлнэ. | ХХСангийн хяналтын зөвлөл улирал бүр хяналт хийж зээлдэгч бүрээр орж, ИТХ тайлагнаж байна.<br>Хоршооны тухай хуулийн 2 төрлийн видео, 2 төрлийн гарын авлагуудыг фэйж хуудас болон групп дээр байршуулж байна. Нийт 45 өрхөд гарын авлага таарсан Ил тод байдлыг хангах ажлууд үр дүнтэй хэрэгжиж байгаа бөгөөд энэ нь иргэдийн итгэлийг нэмэгдүүлж байна. | |
| 3.7 | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих | 3000,0 | Тарьсан, хамгаалсан модны тоогоор | Жил бүр байгууллагын хашаанд болон цэцэрлэгт хүрээлэнд мод тарьдаг. Мод харж хамгаалах нөхцөл бүрдээгүнй улмаас модны ургалт муу байдаг | Цэцэрлэгт хүрээлэн болон байгууллагын хашаанд мод бут тариална. | Энэ хавар цэцэрлэгт хүрээлэнд хуучин үхсэн модын авч шинэ суулгац тарьж нөхөн сэргээлт нийт 200 голт бор , мөн шинээр 350 голт тарсан. Хуучин наадмын талбай 150 улиас мод нөхөн сэргээж тарсан. Байгууллагын хашаанд мод тарихаар төлөвлөсөн модоо худалдаж авсан боловч хашааны тендерээр зарлаад хүн орж ирээгүй байгаа учраас түр хойшлоод байна. | |
| 3.8 | Хөх сав канистергүй сум, баг, өрх, хөдөлгөөн өрнүүлэх, малчдыг сүү цагаан идээгээ хүнсний зориулалтын саванд боловсруулах, хадгалах, тээвэрлэх чиглэлээр арга хэмжээ авах | 1000,0 | Хөх сав, канистергүй болсон айл өрхийн тоогоор | Сумын хэмжээнд бүх өрх хөх сав канистер хэрэглэж байна. | Төрийн албан хаагчдын гэр бүлийн савыг эрүүл зориулалтын саваар солих аян зохион байгуулна. Багуудын | Хүнсний зориулалтын савны талаар мэдээлэлтэй болсон өрхийн тоо: 40.<br>Сумын хэмжээнд хөх сав хэрэглэхээс татгалзсан өрхийн тоо: 174<br>Малчдын хүнсний аюулгүй байдлын талаарх мэдлэг, ойлголт сайжирсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дунд аяны арга хэмжээг зохион байгуулна | Хөх савны хэрэглээний хор уршгийг ойлгуулах, хүнсний зориулалтын савны ач холбогдлыг сурталчлах сургалт, арга хэмжээнүүд үр дүнтэй байлаа. | |
| 3.9 | Сум орон нутагтаа үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, шалгарсан бүтээгдэхүүнийг аймаг, улсын үзэсгэлэн худалдаанд оролцуулахад дэмжлэг үзүүлсэн байх | - | Улс, аймгийн үзэсгэлэн худалдаанд оролцуулсан иргэн, аж ахуй нэгжийн тоо,<br>-Борлуулалтын хэмжээ, сая төг | Сум орон нутагтаа үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан. “Өвөрхангай Түншлэл-2024” намрын баяр, үзэсгэлэн худалдаанд 4 иргэн оролцсон. | Сум орон нутагтаа үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, шалгарсан бүтээгдэхүүнийг улс, аймгийн үзэсгэлэн худалдаанд оролцуулахад дэмжлэг үзүүлсэн байна | 3 дугаар улиралд хийгдэнэ. | |
| 3.10 | Томоохон голуудын дагуух хог хаягдлыг цэвэрлэж, орчны бохирдол үүсэхээс сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах | - | Арга хэмжээний тоогоор | Сумын нутаг дэвсгэрт үүссэн хур хог хаягдлыг цэвэрлэсэн. 1, 6-р багуудад хог хийх нүх ухуулж бэлтгэсэн. | Иргэдээс судалгаа мэдээллийг авч хур хог хаягдлыг цэвэрлэх | Хүрэмт 3-р багийн “Хүрэмт гол”, Ихбулаг багийн “Онгийн гол”, Урт 4-р багийн “Дайргын гол” эдгээр голуудын дагуух хог хаягдлыг багийн дарга болон тухай нутагт оршин сууж байгаа ард иргэдтэй хамтран цэвэрлэж, хог хаягдлын талаар мэдээлэл өглөө | |
| **4.БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРТ** | | | | | | | |
| Зорилт . Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэн, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилж, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1 | Цэрэг татлагын ажлыг зохион байгуулж цэргийн жинхэнэ албанд тэнцэх иргэдийн тоог нэмэгдүүлнэ | 1500,0 | Цэргийн алба хааж буй иргэдийн тоогоор | 5 залуу цэргийн хугацаат албыг биеэр хааж, дүйцүүлэх албыг 1 иргэн хааж байна. | Цэрэгт татагдах залуучуудын судалгааг нэг бүрчлэн гаргаж, цэргийн зарлан дуудах хуудас тарааж, цэрэг татлагын ажлыг 90-ээс дээш хувиар зохион байгуулан ажиллах | | |
| 4.2 | Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийг сургалтанд хамруулах, ажил үүргийг журмын дагуу гүйцэтгэх, цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол хангасан иргэдтэй төлбөрийн тооцоо хийх | 100,0 | Сургалтанд бүрэн хамруулсан байх. Мөнгөн төлбөрийг бүрэн барагдуулсан байх. | Цэргийн албыг биер дүйцүүлэн хааж буй 1 иргэн байна. 1998 оны 21 иргэн мөнгөн төлбөрийн тооцоог бүрэн хийж дуусгасан. | Дүйцүүлэх албыг биеэр хааж буй иргэдийг сургалтанд бүрэн хамруулж, нийгэмд тустай олон нийтийн ажилд дайчлан ажиллуулсан байх. 1999 оны мөнгөн төлбөр төлөх иргэдийн төлбөрийг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүрэн барагдуулсан байх. | | |
| 4.3 | Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгж, дайчилгааны томилгоот нэгжийг шинэчлэх. | - | Бүрэн томилгоожуулж тайлагнасан байдлаар | ОНХТөлөвлөгөөний томилгоот нэгжүүдийг бүрэн томилгоожуулсан. | ОНХТөлөвлөгөөний томилгоот нэгжүүд, орон нутгийн дайчилгааны томилгоог шинэчлэн томилгоожуулсан байна. | | |

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫ

Н ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ТАРАГТ СУМ

# ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 он

БАТЛАВ

СУМЫН ЗАСАГ ДАРГА Х.ДАШДЭЛЭГ

2025 оны ....сарын ....өдөр

АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨР

2025.01.15 Тарагт сум

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Шаардлагатай төсөв /төг/ | Хугацаа | Хариуцах эзэн |
|---|---|---|---|---|
| Нэг. Төрийн албан хаагчийн сургалт | | | | |
| 1 | Төрийн жинхэнэ албанд анх томилогдсон болон ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг богино болон дунд хугацааны сургалтанд хамруулах | - | I-IV | ЗДТГ-ын дарга |
| 2 | Албан хаагчдын албан тушаал тус бүрээр зайлшгүй судлах шаардлагатай ерөнхий хууль, тогтоол шийдвэр, Бодлогын баримт бичиг, хөтөлбөрийн жагсаалтыг гаргаж албан хаагч бүрээр сургаж, чадавхижуулна | - | II | ЗДТГ-ын дарга, Хууль эрх зүйн мэргэжилтэн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | Монгол бичиг сурах үйл явцыг эрчимжүүлж, албан хаагч бүр чөлөөтэй уншиж бичдэг болж суралцахад нөхцөл боломжийг бүрдүүлж өгнө | 100,0 | I-IV | ЗДТГ-ын дарга, Монгол бичгийн ажлын хэсэг |
| 4 | Сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх | - | I-II | ЗДТГ-ын дарга |
| 5 | Төрийн албан хаагчдыг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран сурч хөгжих нөхцөл боломжоор хангах | 500,0 | II | ЗДТГ-ын дарга, Санхүү алба |
| 6 | Төрийн албан хаагчийн манлайлал, харилцаа хандлага, ес зүй, цагийн менежмент зэрэг хувь хүний ур чадварыг хөгжүүлэх | 600,0 | I-IV | ЗДТГ-ын дарга, Ёс зүйн хороо |
| Хоёр. Ажиллах нөхцөл нийгмийн баталгаа | | | | |
| 1 | Ажилчдын санал санаачлагад үндэслэн өрөө тасалгааг тохижуулахад дэмжлэг үзүүлнэ. | 3000,0 | I-II | ЗДТГ-ын дарга |
| 2 | Ажилчдын үдийн амралт болон илүү цагаар ажиллах үед богино хугацаанд алжаал тайлах ( кофи цай уух) өрөөг боломжиндоо тулгуурлан бий болгох | 1000,0 | I | ЗДТГ-ын дарга, албан хаагчид |
| 3 | Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдлын нөхцөлийг сайжруулна. | 5000,0 | I-II | ЗДТГ-ын дарга |
| 4 | Албан хаагчдын амьдрал ахуй, нийгмийн баталгааг хангахад шаардлагатай үед буцалтгүй тусламжийг олгоно | 2000,0 | I-IV | ЗДТГ-ын дарга |
| 5 | Албан хаагч үүргээ гүйцэтгэж байгаатай холбогдуулан түүнийг хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх, ялгаварлан гадуурхах, болон бусад хуул бус үйлдэл гарсан тохиолдолд албан хаагч болон түүний гэр бүлийг хамгаалах | 500,0 | I-IV | ЗДТГ-ын дарга |
| 6 | Гэр бүлийн зөвлөл, дотоод хяналтын баг, ёс зүйн дэд хорооны санал санаачлагад үндэслэн байгууллагын | 800,0 | I-IV | ЗДТГ-ын дарга |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | албан хаагчдын хөгжил, эв нэгдэл, хамт олны уур амьсгалыг сайжруулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлнэ | | | |
| 7 | Байгууллагын албан хаагчид ашгийн бусаар туслах аж ахуй, төмс, хүнсний ногоо тариалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ. | 100,0 | I-III | ЗДТГ-ын дарга |
| 8 | Ганц бие эцэг, эх, шинээр гэр бүл болсон залуу гэр бүлд санхүүгийн болон бусад хэлбэрээр тусламж үзүүлнэ | 1000,0 | I-IV | ЗДТГ-ын дарга, албан хаагчид |
| 9 | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулна | 100,0 | II | ЗДТГ-ын дарга, ЭМТөв |
| 10 | Байгууллага хамт олноороо аливаа хорт зуршлаас татгалзах, амьдралын зөв хэвшил, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх санал санаачлагыг дэмжих | 50,0 | II-III | ЗДТГ-ын дарга, албан хаагчид |
| 11 | Эрүүл аж төрөх, чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэх зорилгоор амралт, аялал зохион байгуулна | 2000,0 | III | ЗДТГ-ын дарга, албан хаагчид |

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:ЗДТГ-ЫН ДАРГА Б.БАТЦЭЦЭГ